



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.04.04 № 3/612
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар “Эрдэнэс Монгол” ХХК-ийн санхүүгийн тайлан болон тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Эрдэнэс Монгол" ХХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

ҮАГ-ын САГ-ын дарга:

Ц.Наранчимэг

Утас: 261663

ҮАГ-ын аудитын менежер:

Я.Самбууням

Утас: 263755

АУДИТЫН ТАЙЛАН

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

ТАБ-ын хаяг

Байршил: Улаанбаатар хот Чингэлтэйдүүрэг,

Бага тойруу-3, Засгийн газрын IV байр

Цахим хуудас www.audit.mn

Од бүртгэл Аудит ХХК

Захирал: У.Оюунаа

Утас: 99051826

Ахлах аудитор: П.Нарантуяа

Утас: 88002718

Аудитор: С.Буманцэцэг

Утас: 88067851

Сүхбаатар дүүрэг 1 хороо,

Олимпийн гудамж, Цэлмэг

тауэрийн 701 тоот

утас, 70150030

email; info@odburtgel.mn

цахим хаяг www.odburtgel.mn

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллагийн түвшин
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Зөвлөмж
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-д зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэс Монгол ХХК-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайланд /ҮАГ-САГ/2017/21/СТА-ТӨҮГ/ аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Эрдэнэс Монгол ХХК-ын 2016 оны нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайлан нь Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хууль, Хүний хөгжил сангийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/ болон нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /НББОУС/ түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдах албан тушаалтан санхүүгийн тайлангаа СТОУС, НББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Эрдэнэс Монгол ХХК-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 02 дугаар сарын 14-ны өдрөөс 2017 оны 03 дугаар сарын 20-ны хооронд хийхээр төлөвлөн Од бүртгэл Аудит ХХК-ийн П.Нарантуяа ахлагчтай аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Эрдэнэс Монгол ХХК нь 2016 оны IV улирлын нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайланг 2017 оны 2 дугаар сарын 17-нд Од бүртгэл Аудит ХХК-д ирүүлсэн байна.

Од бүртгэл Аудит ХХК нь аудитыг 2017 оны 02 дугаар сарын 23-нээс 2017 оны 3 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 3 дугаар сарын 20-нд ҮАГ-ын Санхүүгийн аудитын газраар хянуулж, “Эрдэнэс Монгол” ХХК-д 4 дугаар сарын 5 гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Эрдэнэс Монгол ХХК-ын удирдлага нь Монгол улсын “Компанийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Хүний хөгжил сангийн тухай”, “Ашигт малтмалын тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, Нийгмийн даатгал болон Татварын багц хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тус компанийг байгуулсан Засгийн газрын 2006 оны 266-р тогтоолыг үндэслэн, Төрийн өмчийн хорооны 2007 оны 52 дугаар тогтоолоор үүсгэн байгуулж, компанийн дүрмийг баталсан. Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 104 дугаар тогтоолоор дүрмийг шинэчлэн баталсан байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль болох Хүний хөгжил сангийн тухай хууль 2016 оноос хэсэгчилсэн байдлаар болон 2017 оны 1 дүгээр сараас бүхэлдээ эхлэн хүчин төгөлдөр бус болсон. 2016 оны 1 дүгээр сарын 29-нд Хүнийн хөгжил сангийн тухай хуулинд өөрчлөлт орсноос шалтгаалан Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөл, гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх зэрэгт өөрчлөлт орсон байна.

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Эрдэнэс Монгол ХХК нь санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2011 оны 10 сард гүйцэтгэх захирлын 48 дугаар тушаалаар баталж, санхүүгийн үйл ажиллагаанд мөрдлөг болгохыг даалгасан байна. Бодлогын баримт бичигт байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалж шинээр бий болсон охин компани дахь хөрөнгө оруулалт, Хүний хөгжил сангийн төлбөр тооцоо, давуу эрхтэй хувьцаа, биет бус хөрөнгө, зам ашиглалт, арчлалт, өртөг, зардал, орлогын бүртгэлтэй холбогдсон нарийн төвөгтэй ажил гүйлгээнүүдийг бүртгэх горимыг тусгаагүй байна.

Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотойгоор Нягтлан бодох бүртгэл, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулиуд шинэчлэн батлагдаж, 2016 оны 1 дүгээр сарын 01-ээс мөрдөгдөж эхлээд байна.

Азийн хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээр хэрэгжиж буй “Эрдэнэс Монгол” ХХК-ийн удирдлагын чадавхийг сайжруулах төслийн хүрээнд компанийн удирдлага Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулж, сайжруулах

зорилготой холбогдох стандарт, журмыг судлах, тохиромжтой тооцооллын арга хэрэгслийг тодорхойлох ажлуудыг хийж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Эрдэнэс Монгол” ХХК нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаар “Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээд” бөгөөд Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд болон стратегийн ач холбогдол бүхий эрдэс баялагийг ашиглахтай холбоотой харилцаанд төрийн төлөөллийг хэрэгжүүлэх, Монгол Улсын байгалийн нөөцийг оновчтой ашиглах, эдийн засгийн өсөлтийг хангах, төрөлжсөн эдийн засгийг бий болгох, уул уурхай, дэд бүтэц, эрчим хүч, аж үйлдвэр зэрэг тэргүүлэх салбаруудад хөрөнгө оруулалт хийх үндэсний тэргүүлэгч компани болох гэж компанийн зорилгыг тодорхойлсон байна.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 26.1 дүгээр зүйлд “төрийн өмчит хуулийн этгээд нь өөрт олгогдсон эд хөрөнгийг энэ хуульд заасан журмын дагуу эзэмшиж ашиглана” гэж зааснаар байгууллагын эд хөрөнгийн өмчлөх, ашиглах эрхийг тодорхойлсон байна.

Дээрх зорилго зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлд зааснаар 2016 оны 9 сард Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор томилогдсон Ц.Түмэнцогт гүйцэтгэх захирлын үүргийг гүйцэтгэж, компанийн хөрөнгө санхүү үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, захиран зарцуулж байна.

Гүйцэтгэх удирдлагын Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан Хөлсөөр ажиллах гэрээ, гүйцэтгэх удирдлагаас дэд захирлуудтай хийсэн хөлсөөр ажиллах гэрээний үр дүн буюу гүйцэтгэх удирдлага болон удирдлагын багийн эрх үүрэг, хариуцлага тэдгээрийн хэрэгжилт, үр нөлөөг тооцож чадаагүй.

Эрдэнэс Монгол ХХК-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Эрдэнэс Монгол ХХК-ын 2016 оны нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын дансдын уламжлалт эрсдэл болон

хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эрдэнэс Монгол ХХК-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Эрдэнэс Монгол ХХК-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллагийн түвшин:

Аудитын материаллаг байдлын суурийг төлөвлөлтийн шатанд 2016 оны нийт хөрөнгийн 2 хувиар 4,177,951.5 мянган төгрөгөөр тогтоосон. Аудитыг богино хугацаанд төлөвлөж гүйцэтгэсэн учраас гүйцэтгэлийн үе шатанд материаллагийн суурьт өөрчлөлт оруулаагүй болно.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Эрдэнэс Монгол ХХК-ын байгууллагын хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт дунд байна.

Орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Эрдэнэс Монгол ХХК нь ТУЗ-ын 2016 оны 5 дугаар тогтоолд замын хураамжаар 30,952.0 сая төгрөгийн орлого олох зорилтот түвшин батлагдсанаас, замын хураамжаас 28,482.1 сая төгрөг, менежментийн төлбөрөөс 4,430.1 сая төгрөг, бусад үйл ажиллагаанаас 868.6 сая, нийт 34,414.3 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

“Эрдэнэс Монгол” ХХК нь Таван толгой-Гашуун Сухайт чиглэлийн тусгай зориулалтын хатуу хучилттай авто замын эрчмийг нэмэгдүүлж ашиглалтыг сайжруулах, шороон замын тээвэрлэлтийг зогсоож байгаль экологийг хамгаалах,

цаашид гүйцэтгэх үйл ажиллагааны талаар зам ашиглагч, тээвэрлэгчидтэй хамтран ажиллах зорилгоор Монгол улсын Зам тээврийн сайдын 2015 оны 3 дугаар сарын 31-ний тушаалаар БНХАУ-д нийлүүлэх нүүрсний тээврийн чиглэлийг тогтоосон байна.

Гүйцэтгэх захирлын 2015 оны а/36 тоот тушаалаар 2015 оны 04 дүгээр сарын 01-нээс тээвэрлэлтийн тарифыг 1 тн тутамд 1.00 ам доллар байхаар тогтоосон. Тайлант онд гүйцэтгэх захирлын тушаалаар 1 тн нүүрс тээвэрлэх тарифыг 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд 2,000 төгрөг, 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 3,200 төгрөг байхаар тогтоосон.

Зорилтот түвшний үзүүлэлтээр зам, боомтын зардалд 9,996.2сая, замын зээлийн хүүгийн зардалд 10,835.7 сая, үйл ажиллагааны зардалд 5,046.1 сая төгрөг батлагдсан.

Гүйцэтгэлээр 8,856.7 сая төгрөгийг зам арчлалтын зардалд, үйл ажиллагааны зардалд 12,666.7 сая төгрөг, зээлийн хүүнд 11,379.8сая төгрөг зарцуулж, 150.2 сая төгрөгийн аж ахуйн нэгжийн татвар ногдуулсан байна.

Тайлант оны эцэст санхүүгийн тайланд толилуулсан НӨАТ-ын 513.7 сая, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 25.2 сая төгрөг, нийт 538.9 сая төгрөгийн татварын өр төлбөрийг 2017 оны 1 сард багтаан улсын төсөвт төлсөн байна.

Өмнөх онтой харьцуулахад авто замаарх нүүрс тээвэрлэлтийн тоо, хураамжийн орлого нэмэгдсэн нь тээвэрлэгчээс авах авто зам ашиглалтын хураамжийн авлага 1,578.8 сая төгрөгөөр өсөхөд нөлөөлсөн. Оны эцэст охин компаниудаас авах менежментийн төлбөрийг тооцоолж, орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотойгоор холбоотой талаас авах авлага 5,732.0 сая төгрөгөөр өссөн байна.

Шилэн дансны мэдээлэл

Эрдэнэс Монгол ХХК нь Шилэн дансны тухай хуулийн дагуу өөрийн байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим худалдан авалтын төлөвлөгөө, худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр зэрэг мэдээллийг байршуулсан байна. Түүнчлэн 2017оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендер шалгаруулалтын мэдээллийг оруулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 7 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд нийт 11 чиглэлийн дансдад хяналтын болон нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлж чадвал: Стандарт, дүрэм, журмыг дагаж мөрдөөгүй, татвартай холбогдох тооцооллыг дутуу хийсэн нь санхүүгийн тайлангийн үнэн зөв

байх, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга тодруулга, эрх үүргийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Эрдэнэс Монгол ХХК-ын 2016 оны нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний бараа материал, үндсэн хөрөнгө, үйл ажиллагааны орлого, авлага, өглөг, зээл, зээлийн хүү, борлуулсан бүтээгдэхүүний өртөг зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 26.2 хувь, нийт зардлын 66 хувь, нийт хөрөнгийн 64 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант онд гарсан онцлог ажил гүйлгээний хувьд:

- Тайлант онд Азийн хөгжлийн банкнаас “Эрдэнэс Монгол ХХК-ийн үйл ажиллагааны эрсдэлийн болон санхүүгийн нэгдсэн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд 35,000.0 мянган долларын зээл авах гэрээ байгуулж, тайлант онд 5,227.6 мянган ам долларыг хүлээн авсан. Зээлийг 2019 оны 9 дүгээр сараас эхлэн 12 жилийн хугацаанд зээлийн хүүгийн хамт төлнө. Зээлдэгч нь зээлийн гэрээний дагуу хүлээсэн үүргийн гүйцэтгэлд Монгол улсыг төлөөлж Сангийн сайд баталгаа гаргасан байна. Баталгааны эрх үүргийн хүрээнд Сангийн яам нь Эрдэнэс Монгол ХХК-тай “Засгийн газрын өрийн баталгааны авлага барагдуулах гэрээ”-г 2016 оны 6 дугаар сарын 3-нд байгуулсан. Засгийн газар өрийн баталгаа гаргах болсонтой холбогдуулж, Засгийн газрын өрийн баталгааны санд баталгаа гаргуулагч Эрдэнэс Монгол ХХК нь 5,250.0 мянган ам доллар буюу 10,530.0 сая төгрөгийн шимтгэл байршуулж, тайлант хугацаанд 526.5 сая төгрөгийг шимтгэлийн зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.
- Засгийн газрын 2016 оны 44 дугаар тогтоолоор Засгийн газрын 2014 оны 274 дүгээр тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулж “Оюутолгой төслийн санхүүжилтийн үр ашигтай байдлыг хангах, төслийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай стратеги, санхүү, хууль болон олон нийтийн харилцааны зөвлөх үйлчилгээнд зориулан гаргасан 10 /арван/ сая хүртэлх ам долларын санхүүжилтийн үлдэгдлийг “Эрдэнэс Оюутолгой” ХХК болон “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулах, санхүүжилт татах, стратегийн ач холбогдол бүхий орд газруудыг эдийн засгийн эргэлтэнд оруулахтай холбоотой үйл ажиллагаанд зарцуулахыг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл, Эрдэнэс Монгол ХХК-ийн гүйцэтгэх захирал нарт даалгасугай” гэж заасан байна. Эрдэнэс Оюу Толгой ХХК нь Оюу толгой

төслийн зөвлөх үйлчилгээний хүрээнд гэрээгээр хүлээсэн үүргээ Эрдэнэс Монгол ХХК-д шилжүүлсэн. Эрх үүрэг шилжиж ирснээр 2015 онд Оюу толгой төслийн хүрээнд Эрдэнэс Оюу толгой ХХК-д үзүүлсэн үйлчилгээний төлбөрт АНУ-ын “Ширман ба Стерлинг” ББН-д 1,535.2 мянган ам доллар буюу 3,231.6 сая, Компрадор ХХК-д 1,169.6 мянган ам доллар буюу 2,444.0 сая төгрөгийг тус тус төлсөн. Гадаад гуйвуулгатай холбоотойгоор оршин суугч бус татвар төлөгчийн НӨАТ, ААНОАТ-т 1,668.5 сая төгрөгийн татвар төлсөн байна.

- Засгийн газрын 2015 оны 449 дүгээр тогтоолын дагуу Тавантолгой -Гашуун сухайт чиглэлийн 239 км хүнд даацын, тусгай зориулалтын авто зам, Гашуун сухайт боомтын дэд бүтцийг Эрдэнэс Монгол ХХК-д шилжүүлсэнтэй холбоотойгоор Хөгжлийн банкнаас олгосон 170,595.5 сая төгрөгийн зээлийг төлөх хугацааг, эргэн төлөлтийг зохицуулсан 2/800 тоот гэрээг 2015 оны 12 дугаар сарын 31-нд Хөгжлийн банк, Сангийн яамны төлөөлөлтэй баталгаажуулсан байна. Гэрээнд үндсэн зээлийг 2019, 2020 онд 2 үе шаттайгаар төлөх, хуримтлагдсан хүүг 2017 онд багтаан төлөх, үндсэн хүүг хуваарийн дагуу төлөхөөр заасан байна. 2016 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар үндсэн зээлийн өр 170,595.5 сая төгрөг, хуримтлагдсан хүүгийн өглөг 13,107.5 сая төгрөг байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус хэмжээний дараах алдаа гарсныг шийдвэрлэсэн байдлыг тэмдэглэвэл:

Ажиглалт 1:Гашуун сухайт авто зам ХХК-д ашиглуулж байгаа 87 нэр төрлийн 265.7 сая төгрөгийн хөрөнгийг ажиглалтын шаардлага хангахгүй байгаа шалтгаанаар актлах хүсэлтийг ашиглагч тал 2016 оны 8 дугаар сард ирүүлсэн боловч шийдвэрлээгүй байна. Санхүүгийн тайланд өгөөж авчрахгүй байгаа хөрөнгийг толилуулсаар байна.Энэ нь санхүүгийн тайланд хөрөнгө илүү толилуулагдсан санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдэл хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Ажиглалтын шаардлага хангахгүй байгаа хөрөнгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн актлах тухай зөвлөмж хүргүүлсэн.

Ажиглалт 2:Гадаад валютаар илэрхийлэгдсэн зээл, өр төлбөрийн бодит бус ханшийн зөрүүг татварын тайланд түр зөрүүгээр тайлагнасан. Хойшлогдсон

ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК-ИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

татварын хөрөнгө, өр төлбөр үүсгээгүй 116.1 сая төгрөг нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, толилуулга тодруулга батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:НББОУС 12 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө, Сангийн сайдын 2010 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан “Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах” журмын дагуу хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг үүсгэх талар зөвлөмж хүргүүлсэн.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээр тооцоолох арга, дансны бичилтийг тодорхойлоогүйгээс стандарт журам зааврыг хэрэгжүүлээгүйгээс гарсан 381.8 сая төгрөгийн алдааг залруулаагүй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

➤ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААР

Эрдэнэс Монгол ХХК нь 2016 оны нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайланд 751.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг толилуулсан байна. Үүнд:

№	Компанийн нэр	Эзэмшлийн хувь	Оны эхэнд /сая төгрөгөөр/	Оны эцэст /сая төгрөгөөр/	Тайлбар
1	Эрдэнэс Оюу Толгой ХХК	100%	300.0	300.0	
2	Эрдэнэс Таван Толгой ХК	100%	300.0	300.0	
3	Эрдэнэс Шивээ Энержи ХХК	50%	-	50.0	Тайлант онд шинээр үүсгэн байгуулсан.
4	Эрдэнэс Ассет Менежмент ХХК	100%	-	100.0	Тайлант онд шинээр үүсгэн байгуулсан.
5	Эрдэнэс Метан ХХК	100%	-	1.0	Тайлант онд шинээр үүсгэн байгуулсан.
	Нийт			751.0	

Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 02 дугаар сарын 68 дугаар тогтоолд Эрдэнэс Таван Толгой ХХК-ийн 100%, Эрдэнэс Оюу толгой ХК-ийн 100%, Багануур ХК-ийн 75%, Шивээ-Овоо ХК-ийн 90%, Мон-Атом ХХК-ийн 100%, Гермонт газ ХХК-ийн 51%-ийн төрийн эзэмшлийн төлөөллийг Эрдэнэс Монгол ХХК хэрэгжүүлэхээр заасан боловч уг тогтоол нь 2016 оны 8 дугаар сарын 35 дугаар тогтоолоор хүчингүй болсон.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх” журамд Эрдэнэс Монгол ХХК-ийн харъяанд Эрдэнэс Таван Толгой ХХК, Эрдэнэс Оюу толгой ХК, Багануур ХК, Шивээ-Овоо ХК, Мон-Атом ХХК зэрэг компаниудыг шилжүүлж, Эрдэнэс Монгол ХХК-ийн дүрмээр эдгээр охин компаниудын ТУЗ-ийн дарга, гишүүдийг томилохоор тусгасан байна.

Дээр дурдсан харъяа компаниудын дүрэмд /Эрдэнэс Таван Толгой ХК-иас бусад/ “.. төрийн мэдлийн хувьцааг эзэмшигч нь Эрдэнэс Монгол ХХК /цаашид “Толгой компани” гэх/ мөн бөгөөд толгой компанийн бодлого шийдвэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулна” гэж өөрчлөлт оруулсан байна. Гэвч Багануур ХК, Шивээ-Овоо ХК, Мон-Атом ХХК-ийн төрийн эзэмшлийн хувь буюу толгой компани эзэмшиж буй хувьд тохирох хөрөнгө оруулалтыг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Багануур ХК-д оруулсан хөрөнгө оруулалтын талаар:

Багануур ХК-ийн 2016 оны 4 дүгээр сард шинэчлэн баталсан дүрмээр нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 20,974,360 ширхэг гаргасан хувьцаатай бөгөөд үүний 75% буюу 15,370,770 ширхэг 1,537.08 сая төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий хувьцааг Эрдэнэс Монгол ХХК эзэмшихээр тогтоосон байна. Багануур ХК-иас 2016 онд олон нийтэд зарласан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 9,870,287 ширхэг энгийн хувьцаатай холбогдох бүртгэл болон шийдвэрийг мөшгин шалгаж амжаагүй учраас Эрдэнэс Монгол ХХК-ийн эзэмшиж буй хувь оролцоо, бүртгэх дүнг тодорхойлж чадаагүй. Тус компанийн нэмж гаргасан хувьцаа нь 2016 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Хөрөнгийн биржид бүртгэгдсэн бөгөөд бүртгэгдсэн нийт хувьцааны тоо 30,844,647 ширхэг байна.

Шивээ-Овоо ХК-д оруулсан хөрөнгө оруулалтын талаар:

Шивээ-Овоо ХК-ийн 2016 оны 4 дүгээр сард шинэчлэн баталсан дүрмээр нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 13,419,101 ширхэг зарласан хувьцаатай бөгөөд үүнээс хэдэн хувийг Эрдэнэс Монгол ХХК эзэмшихийг тодорхой заагаагүй байна. Хөрөнгийн бирж дээр Шивээ-Овоо ХК-ийн нийт гаргасан хувьцааны тоог 13,419,101 ширхэг байгаагаас хэдэн хувийг төрийн мэдэлд байгааг мөшгин шалгаж чадаагүй.

Мон-Атом ХХК-д оруулсан хөрөнгө оруулалтын талаар:

Мон-Атом ХХК-ийн 2016 оны 7 дугаар сард шинэчлэн баталсан дүрмээр нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 100.0 мянган ширхэг гаргасан хувьцааг 100% Эрдэнэс Монгол ХХК эзэмшихээр заасан байна.

Эрдэнэс Таван Толгой ХК-д оруулсан хөрөнгө оруулалтын талаар:

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолд “....*Таван толгойн нүүрсний ордод ашиглалтын үйл ажиллагаа явуулах төрийн өмчит компанийг хууль тогтоомжийн дагуу байгуулж, 20 хүртэлх хувийг Монгол Улсын иргэнд үнэ төлбөргүй эзэмшүүлэх, 10 хүртэлх хувийг үндэсний аж ахуйн нэгжүүдэд нэрлэсэн үнээр тэнцүү хэмжээгээр худалдах, 20 хүртэлх хувийг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр худалдаж, шаардлагатай хөрөнгө оруулалтыг татахыг.....*” заасан байна. Дээрх тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газар 2010 оны 272 дугаар тогтоолоор Эрдэнэс Таван Толгой ХК-ийг байгуулж, компанийн өөрийн хөрөнгийг бүрдүүлэхэд шаардлагатай хөрөнгийг Эрдэнэс Таван Толгой ХК-ийн толгой компани болох Эрдэнэс Монгол ХХК-аас гаргуулахаар шийдвэрлэсэн байна. Уг шийдвэрийн дагуу Эрдэнэс Монгол ХХК нь тухайн үед шилжүүлсэн хөрөнгийн дүнгээр хөрөнгө оруулалтыг бүртгэсэн байна.

Эрдэнэс Таван толгой ХХК нь 2010 оны ТӨХ-ны хорооны 39 дүгээр тогтоолоор батлагдсан дүрэмд 15 тэрбум ширхэг зарласан хувьцаатай байхаар заасан бөгөөд одоогийн байдлаар гаргасан хувьцааны тоо, нэрлэсэн үнэ тогтоогдоогүй байна.

Тус хөрөнгө оруулалтууд нь Засгийн Газрын зүгээс шилжүүлсэн төрийн төлөөллийг хэрэгжүүлэх эрх бөгөөд дээр дурдсан тогтоол, журамд шилжиж ирсэн хөрөнгө оруулалтыг санхүүгийн тайланд хэрхэн бүртгэх талаар тодорхой тусгаж өгөөгүй байна. Өөрөөр хэлбэл Эрдэнэс Монгол ХХК-ийн зүгээс охин компаниудыг эзэмшихтэй холбоотойгоор хөрөнгө шилжүүлээгүй байна.

Охин компанийн төлөөлөх эрх буюу хөрөнгө оруулалтыг СТОУС 9 *Санхүүгийн Хэрэглүүр*, СТОУС 13 *Бодит Үнэ Цэнийн Хэмжилт* стандартын дагуу өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт гэж үзээд түүнийг анх удаа санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр нь хэмжих ёстой. Бодит үнэ цэн нь тухайн хөрөнгө оруулалтын өртгийн дүнтэй ойролцоо байгаа эсвэл бодит үнэ цэнийг тодорхойлох хамгийн сүүлийн үеийн мэдээлэл хүрэлцээгүй байгаа тохиолдлуудад өртгөөр нь хүлээн зөвшөөрөхийг СТОУС шаардсан байна. Гэвч аудиторын зүгээс цаг хугацааны хязгаарлагдмал байдал, мэдээллийн олдоц байхгүйгээс Засгийн газрын тогтоолоор шилжиж ирсэн дээрх хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг тооцоолоогүй.

Хэрвээ дээрх хөрөнгө оруулалтыг үнэ төлбөргүй хүлээн авсан гэж үзээд НББОУС 20 *Засгийн Газрын Буцалтгүй Тусламжийн Нягтлан Бодох Бүртгэл ба Туслалцааны Тодруулга*-ын дагуу олз буюу санхүү тайланд ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ гэвэл:

- Хөрөнгө оруулалтын бодит үнэ цэн буюу өртөг тодорхойгүй;

- Хүлээн зөвшөөрөх олзын дүнгээс тооцож НӨАТ болон ААНОАТ ногдох эрсдэл үүсэхээр байна.

Хүснэгтэд дурдсан компаниудын хөрөнгө оруулалтыг Эрдэнэс Монгол ХХК-аас шилжүүлсэн хөрөнгийн дүнгээр буюу өртгөөр нь бүртгэсэн бөгөөд Засгийн газраас шилжин ирсэн хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэн буюу өртгөөр нь бүртгэх боломжгүй байна.

Дээр дурдсанчилан Багануур ХК, Шивээ-Овоо ХК, Эрдэнэс Таван Толгой ХК-ийн хувьцаанаас Эрдэнэс Монгол ХХК-ийн эзэмшиж буй хувь оролцоо буюу хувьцааны тоо хэмжээг тодорхойлох боломжгүй байна. Иймээс Эрдэнэс Монгол ХХК нь охин компаниудын гаргасан хувьцаанаас өөрийн эзэмшлийн хувь буюу хувьцааны тоо хэмжээг тодорхой болгож, Засгийн газрын холбогдох шийдвэрээр охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалтын дүнг бүртгэлийн нэг суурь, зарчмын дагуу тооцоолж, санхүүгийн тайланд тусгах нь зүйтэй.

- Засгийн газрын 2013 оны 347 дугаар тогтоолоор батлагдсан Эрдэнэс Монгол ХХК-ийн дүрмийн 4 дүгээр бүлэгт Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь гаргасан энгийн болон давуу эрхийн хувьцааны үнийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна. Давуу эрхийн хувьцаа нь нэг бүр нь 1 /нэг/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 3,000.0 мянган ширхэг байх бөгөөд компани нь Монгол улсын иргэн бүрт олгох давуу эрхийн хувьцааг Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн нэгдсэн сангийн албан ёсны тоон мэдээлэлд үндэслэн гаргах бөгөөд Хүний хөгжил сангийн 15.1-д заасан шаардлагыг хангасан Монгол улсын иргэнд үнэ төлбөргүй эзэмшүүлэхээр заасан байсан. Харин Засгийн газрын 2016 оны 104 дүгээр тогтоолоор баталсан Компанийн дүрмийн 6 дугаар бүлэгт нэг бүр нь 1 /нэг/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 3,0 сая ширхэг давуу эрхийн зарласан хувьцаатай байхаар заасан бөгөөд дээрх хувьцааг хэзээ хэнд зориулж гаргах талаар заагаагүй байна.
- Гашуунсухайтын авто замыг дагаж ирсэн боомтыг хил, гаалийн төрийн захиргааны байгууллага ашиглаж байгаа бөгөөд дээрх хөрөнгийн ашиглалт нь авто замын ашиглалттай хамааралгүй болон тус компанийн үйл ажиллагаанд зориулагдаагүй учраас холбогдох газарт шилжүүлнэ гэж үзээд санхүүгийн тайлангийн эргэлтийн хөрөнгийн хэсэгт Борлуулах зорилгоор эзэмшиж байгаа хөрөнгөөр бүртгэж, толилуулж байна. Одоогоор дээрх биет хөрөнгөнд элэгдэл хорогдол, үнэ цэнийн бууралтыг тооцоогүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

- Эрдэнэс Монгол ХХК нь 2016 онд албан ёсоор нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргаагүй бөгөөд бидний аудитын ажил нь зөвхөн Эрдэнэс Монгол ХХК-ийн

нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайланг, 2016 үйл ажиллагаа, санхүүг хамруулсан бөгөөд тус компанийн хөрөнгө оруулсан охин болон хараат компанийн хөрөнгө оруулалт, бүртгэл тайлагналыг хамруулаагүй болно. Иймд дараагийн аудитаар нэгтгэсэн тайланг бэлтгэх үзэл баримтлал, нэгтгэлийн процессыг үнэлэх шаардлагатай.

- Эрдэнэс Монгол ХХК нь 2014 онд Гашуун сухайт Авто зам ХХК /Эрдэнэс таван толгой ХХК, Энержи Ресурс ХХК, Таван толгой ХК/-тай байгуулсан ER-14-127 тоот “Ухаа худаг Гашуун сухайт чиглэлийн авто замын ашиглалт, үйлчилгээ, засвар арчилгааг гүйцэтгэх” гэрээний дагуу тус замаар тээвэрлэсэн нүүрс болон уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн тоо бүртгэл хөтлөлт, авто замын тариф, хураамжийн орлого цуглуулалт, авто замын ашиглалт, арчлалт, урсгал болон их засварын ажилд гарсан зардлыг гүйцэтгэлээр нь санхүүжүүлж байна. Авто замын ашиглалт, арчлалт, урсгал болон их засварын ажилд гарсан зардлыг техник ашиглалтын түвшингээр тогтоогдсон засварын ажлын төлөвлөгөө, график, ажлын гүйцэтгэлээр хянадаг. Тайлант онд өртгийн дансанд 8,856,674.6 мянган төгрөгийг хуримтлуулан бүртгэснээс зам засвар, арчлалт, урсгал болон их засвартай холбоотой зардал нь 5,135,751.7 мянган төгрөг, үлдэх 3,720,922.9 мянган төгрөгийн өртөг нь Гашуун Сухайт авто зам ХХК-ийн борлуулалт, удирдлага болон зам ашиглалтын зардал байна. Тайлант онд Гашуун сухайт авто зам ХХК-ийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудитын дүгнэлт гараагүй байсан учраас зөвхөн тооцоо нийлсэн актаар өртөгийг баталгаажуулсан.
- Тайлант онд Азийн хөгжлийн банкны зээлийн эх үүсвэрээр хэрэгжиж байгаа төслийн хүрээнд гарсан зардлыг үйл ажиллагааны зардлаас тусад нь бүртгэсэн байна. Бидэнд ирүүлсэн мэдээллээр “Эрдэнэс Монгол” ХХК-ийн удирдлагын чадавхийг сайжруулах төслөөс гадна 10 гаруй төсөл хөтөлбөр байна. Бид дээрх төслүүд нь цаашид хэрэгжих эсэх, эсвэл зөвхөн судалгааны шатанд байгаа эсэх, тайлант үед гаргасан зардал болон төслийн үр дүнг үнэлээгүй.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2016 оны нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 381.8сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба 381.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

2015оны санхүүгийн тайланд Од бүртгэл аудит ХХК аудит хийж,Эрдэнэс Монгол ХХК-ийн удирдлагад 8 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийн 80 хувийг хэрэгжүүлж, 20 хувийг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

Гашуунсухайтын авто замыг дагаж ирсэн боомтыг холбогдох газарт нь шилжүүлэхээр хүсэлт тавьсан боловч одоогоор шийдвэрлэгдээгүй байна.

Төрийн байгууллагаас тодорхой шийдвэр гараагүй учраас Таван Толгой - Гашуун сухайт чиглэлийн 239км хүнд даацын, тусгай зориулалтын автозамыг эзэмших эрхийн хугацааг тодорхой болгож, хөрөнгийн дансны үнэ, хуримтлагдсан хорогдлыг тодорхой болгох зөвлөмж хэрэгжээгүй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Бидний үзэж байгаагаар, Эрдэнэс Монгол ХХК-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, НББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.



ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК-ИЙН 2016 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Тайлагналын талаар

Асуудал 2

Хөрөнгө оруулалтын талаар

Тэргүүлэх ач холбогдол № 2 зүйлс:

Асуудал 3

Эргэлтийн бус хөрөнгийн талаар

Менежментийн захидал

Од бүртгэл Аудит ХХК аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Эрдэнэс Монгол ХХК-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Эрдэнэс Монгол ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч Б.Чойжил болон санхүү, захиргааны холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Тайлагналын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

Аудитын багийн ажиглалт

- 2015 онд “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн авсан зөвлөх үйлчилгээний үүрэг хариуцлагыг толгой компанид шилжүүлэх гэрээг 2016 оны 3 дугаар сард байгуулсан. Уг гэрээний дагуу үүрэг хариуцлага шилжиж ирмэгц өр төлбөрийг бүртгээгүй бөгөөд 7.2 тэрбум төгрөгийн төлбөр хийсэн үедээ тайлант оны гэрээт ажлын зардлаар бүртгэсэн.
- Гадаад валютаар илэрхийлэгдсэн зээл, өр төлбөрийн ханшийн зөрүүг тооцсон дүнгээс 116.1 сая төгрөгийн хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр үүсгээгүй байна.

Зөвлөмж

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт охин компанитай хийсэн ажил гүйлгээ, үйл явдал, нөхцөл байдлыг хэрхэн бүртгэх, тодруулах тухай тусгаж өгөх.
- НББОУС 12 *Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө*, Сангийн сайдын 2010 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан “Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах” журмын дагуу хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг үүсгэх.

Эрсдэл

Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, толилуулга тодруулга батламж мэдэгдлийн хангахгүй байгаагаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэн байна.

Үйлчлүүлэгчийн хариу

Цаашид анхааран ажиллана.

Асуудал 2: Хөрөнгө оруулалтын талаар

Тэргүүлэх ачхолбогдол №1

Аудитын багийн ажиглалт

- Эрдэнэс Монгол ХХК-ийн санхүүгийн тайланд Эрдэнэс Оюу толгой ХХК, Эрдэнэс таван толгой ХК, 2016 онд шинээр үүсгэн байгуулагдсан Эрдэнэс метан ХХК, Эрдэнэс ассетс менежмент ХХК, Эрдэнэс Шивээ энерги ХХК-д оруулсан хөрөнгө оруулалтыг бүртгэж тайлагнасан. Харин Багануур ХК-ийн хувьцааны 75%, Шивээ Овоо ХК-ийн хувьцааны 90%, 2016 оны 2 сард үүсгэн байгуулсан Шинэ Шивээ ХХК-ийн 50% , Мон Атом ХХК -д оруулсан хөрөнгө оруулалтыг бүртгэж тайлагнаагүй.
- "Эрдэнэс таван толгой" ХХК-ийн хувьцаанаас "Эрдэнэс Монгол" ХХК-д хамаарах хувьцааны тоо тодорхойгүй.

Зөвлөмж

- Хөрөнгө оруулалтыг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалтыг бүртгэх аргыг тодорхой тодруулах.
- "Эрдэнэс Монгол" ХХК-ийн эзэмшиж байгаа "Эрдэнэс таван толгой" ХХК-ийн хувьцааны тоо, хөрөнгө оруулалтын дүнг тодорхой болгох.

Эрсдэл

Охин компаниудын хөрөнгө оруулалтыг санхүүгийн тайланд толилуулаагүйгээс шалтгаалж хөрөнгө дутуу илэрхийлэгдэх, ингэснээр нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх боломжгүйд хүрэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Цаашид анхааран ажиллана.

Асуудал 3: Эргэлтийн бус хөрөнгийн талаар Тэргүүлэх ачхолбогдол №1

Аудитын багийн ажиглалт

- Гашуун сухайт авто зам ХХК-д ашиглуулж байгаа 87 нэр төрлийн 265.7 сая төгрөгийн хөрөнгийг ашиглалтын шаардлага хангахгүй байгаа шалтгаанаар актлах хүсэлтийг ашиглагч тал 2016 оны 8 дугаар сард ирүүлсэн боловч шийдвэрлээгүй байна. Санхүүгийн тайланд өгөөж авчрахгүй байгаа хөрөнгийг толилуулсаар байна.

Зөвлөмж

- Ашиглалтын шаардлага хангахгүй байгаа хөрөнгийг тодорхой шийдвэрийг үндэслэн актлах.

Эрсдэл

Энэ нь санхүүгийн тайланд хөрөнгө илүү, дутуу толилуулагдсан санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдэл хангахгүй байна.

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвшөөрсөн

ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК-ИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК-ИЙН 2016 ОНЫ
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	165,254,973.41	9,146,141,635.63
Дансны авлага	2,478,424,700.25	4,057,270,329.55
Татвар, НДШ – ийн авлага	15,875,433,748.54	109,900,597.89
Бусад авлага	15,568,169,013.00	21,300,119,958.36
Бараа материал	47,100,553.52	37,709,175.94
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	194,957,723.86	10,413,112,816.37
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	11,589,359,171.46	11,589,359,171.46
Эргэлтийн хөрөнгийн дүн	45,918,699,884.04	56,653,613,685.20
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	1,453,284,444.90	1,581,937,170.87
Биет бус хөрөнгө	157,082,657,614.53	157,097,473,789.88
Урт хугацаат хөрөнгө оруулалт	652,438,900.00	751,000,000.00
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		46,788,491.67
Бусад эргэлтийн бус хөрөнгө	3,790,491,730.65	5,171,603,687.06
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	162,978,872,690.08	164,648,803,139.48
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>208,897,572,574.12</u>	<u>221,302,416,824.68</u>
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	1,142,173,755.82	191,990,010.12
Цалингийн өглөг	0.99	57,553.26
Татварын өр	162,299.50	538,928,233.79
Банкны богино хугацаат зээл	171,745,479,703.17	-
Хүүний өглөг	11,749,324,091.65	13,622,744,926.25
Урьдчилж орсон орлого		

ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК-ИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

	-	60,000.00
Бусад богино хугацаат өр төлбөр	805,019,767.21	457,471,364.98
Богино хугацаат өр төлбөрийн дүн	185,442,159,618.34	14,811,252,088.40
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	-	183,753,316,158.41
Бусад урт хугацаат өр төлбөр	72,134,382,480.36	71,417,743,738.81
Урт хугацаат өр төлбөрийн дүн	72,134,382,480.36	255,171,059,897.22
Өр төлбөрийн нийт дүн	257,576,542,098.70	269,982,311,985.62
Эздийн өмч		
Өмч:	100,000,000.00	100,000,000.00
- төрийн	100,000,000.00	100,000,000.00
Нэмж төлөгдсөн капитал	385,947,248.97	-
Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
Хуримтлагдсан ашиг	(49,164,916,773.55)	(48,779,895,160.94)
Эздийн өмчийн дүн	(48,678,969,524.58)	(48,679,895,160.94)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	208,897,572,574.12	221,302,416,824.68

ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК-ИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК-ИЙН 2016 ОНЫ
АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	10,764,698,838.39	33,780,689,091.79
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	5,419,628,931.01	8,856,674,613.30
Нийт ашиг (алдагдал)	5,345,069,907.38	24,924,014,478.49
Түрээсийн орлого	-	-
Хүүний орлого	219,976,737.36	633,680,090.70
Ерөнхий ба удирдлагын зардал	3,238,601,437.55	12,666,714,384.00
Санхүүгийн зардал	10,676,995,190.95	11,379,833,914.94
Бусад зардал	-	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	290,330.19	(1,162,804,257.81)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(9,283,905.40)	-
Бусад ашиг (алдагдал)	(118,784,105.47)	(146,667,151.17)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(8,478,327,664.44)	201,674,861.27
Орлогын татварын зардал	21,997,673.73	150,161,597.63
Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	<u>(8,500,325,338.17)</u>	<u>51,513,263.64</u>
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	<u>(8,500,325,338.17)</u>	<u>51,513,263.64</u>
Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
Бусад олз (гарз)	-	-
Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	<u>10,984,675,575.75</u>	<u>34,414,369,182.49</u>
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК-ИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК-ИЙН 2016 ОНЫ
АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч ◀	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг ◀	Нийт дүн ◀
2015 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	100,000,000.00	385,947,248.97	(5,150,736,180.36)	(4,664,788,931.39)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(35,513,855,255.02)	(35,513,855,255.02)
Залруулсан Үлдэгдэл	100,000,000.00	385,947,248.97	(40,664,591,435.38)	(40,178,644,186.41)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(8,500,325,338.17)	(8,500,325,338.17)
Бусад дэлгэрэнгүй орлого				-
Өмчид гарсан өөрчлөлт				-
Зарласан ногдол ашиг				-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	100,000,000.00	385,947,248.97	(49,164,916,773.55)	(48,678,969,524.58)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			333,508,348.97	333,508,348.97
Залруулсан Үлдэгдэл	100,000,000.00	385,947,248.97	(48,831,408,424.58)	(48,345,461,175.61)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			51,513,263.64	51,513,263.64
Бусад дэлгэрэнгүй орлого				-
Өмчид гарсан өөрчлөлт				-
Зарласан ногдол ашиг				-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	100,000,000.00	385,947,248.97	(48,779,895,160.94)	(48,293,947,911.97)

ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК-ИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК-ИЙН 2016 ОНЫ
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	15,141,280,580.24	32,786,440,371.79
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	15,008,572,733.24	29,478,706,722.79
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	11,542,704.00	-
Буцаан авсан албан татвар	-	3,200,000,000.00
Бусад мөнгөн орлого	121,165,143.00	107,733,649.00
Мөнгөн зарлагын дүн	17,030,776,413.95	35,596,634,334.90
Ажиллагчдад төлсөн	1,437,384,077.69	2,590,650,647.86
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	319,921,713.02	498,095,962.72
Бараа материал худалдан авахад төлсөн	467,133,627.28	122,449,720.00
Ашиглалтын зардалд төлсөн	21,913,308.00	4,604,509.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	92,829,786.23	88,808,285.00
Хүүний төлбөрт төлсөн	5,545,507,945.21	8,793,492,209.22
Татварын байгууллагад төлсөн	159,565,619.09	439,027,557.90
Даатгалын төлбөрт төлсөн	8,467,300.00	-
Бусад мөнгөн зарлага	8,978,053,037.43	23,059,505,443.20
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<u>(1,889,495,833.71)</u>	<u>(2,810,193,963.11)</u>
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	47,308,968.86	476,253,835.52
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	34,242,750.33	315,058,154.80
Хүлээн авсан хүүний орлого	13,066,218.53	161,195,680.72
Мөнгөн зарлагын дүн	198,534,633.61	181,441,237.70
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	156,393,100.00	147,095,697.70
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	42,141,533.61	34,345,540.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<u>(151,225,664.75)</u>	<u>294,812,597.82</u>
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн	1,150,435,792.91	13,767,445,058.69
Зээл авсан, өөрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,150,000,000.00	13,767,445,058.69
Бусад	435,792.91	-

ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК-ИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Мөнгөн зарлагын дүн	-	2,380,000,000.00
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	2,380,000,000.00
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<u>1,150,435,792.91</u>	<u>11,387,445,058.69</u>
Валютын ханшийн зөрүү		108,822,968.82
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	<u>(890,285,705.55)</u>	<u>8,980,886,662.22</u>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,055,540,678.96	165,254,973.41
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	165,254,973.41	9,146,141,635.63